



103Page



104Page



105Page



106Page



107Page



108Page

# Суумгай хүнийг эдгээсэн

-Peter (Petr Heals the Crippled Beggar)-

Нэгэн өдөр Петр, Иохан хоёр залбирахаар сүм рүү явж байв. Тэр хоёр сүмийн үүдэнд сууж байгаа хүнийг харав. Тэр хүн төрөлхийн суумгай нэгэн бөгөөд нэг ч удаа алхаж үзээгүй хүн байлаа.

Тэр сүм рүү орж гарч байгаа хүмүүсээс гүйлгээ гүйж байв. Петр, Иохан хоёрыг дөхөн ирэхийг хараад суумгай хүн гүйлгээ гүйв. “Надад туслаач”.

Харин Петр, Иохан хоёрт мөнгө байсангүй. “Наашаа хар.” Суумгай хүн тэр хоёр руу харахад Петр хэлэв. “Алт мөнгөний аль нь ч байхгүй ч өөртөө байгаа зүйлийг өгье.” Суумгай хүн ямар нэгэн чухал юм өгөх нь дээ гэж бодон гарсаа тоссов.

Петр суумгай хүнд хэлэв.

“Назарын Есүсийн нэрээр босоод алх.” Петр түүний баруун гарасаас өргөөд босгов.

Суумгай хүний хөлөнд хүч орохыг мэдэрж өөрийн эрхгүй босов. Тэр маш их баярлаж яахаа мэдэхгүй байлаа. Тэгээд Петр, Иохан хоёрын араас сүм рүү орж алхаж, гүйж, цовхорч үзэн Бурханд талархан магтаж байлаа.

Сүмд залбирахаар ирсэн хүмүүс үүнийг хараад бүгд цугларч ирэв. “Хүү, тэр сүмийн үүдэнд гүйлгээ гүйдаг суумгай хүн мөн биз дээ?”, “Мөнөөр барах уу, тэр хүн байна ш дээ, юу болсон юм бол?” хүмүүс ихэд гайхсан учир хоорондоо ийнхүү ярилцаж байлаа.

Эдгэрсэн хүн Петр, Иохан хоёрыг дагаж явсангаа ингэж хашгирав. “Энэ хүмүүс миний хөлийг эдгээж өгсөн”

Хүмүүс Петр, Иохан хоёрыг харахаар цуглараав. Петр хүмүүст ийн хэлэв.

“Бид энэ хүнийг эдгээсэн юм биш. Бид та нартай яг адилхан жирийн хүмүүс.”

Бурханы хүү Есүс энэ хүнийг эдгээсэн юм”

Петр хүмүүст гэмшиж, Бурханд итгэн хичээнгүй амьдраарай гэж хүмүүст заав.

Энэ үед сүмд ажилладаг байсан тахилч болон ажилчид Есүс дагалдагч нар хүмүүст сайн мэдээ тарааж байхыг хараад ихэд уурлав. Тэд үхээд амилсан Есүсийн тухай ярихыг сонсоод бүр ч тэвчиж чадахгүй байв. Тэд цэргүүдээр тэр хоёрыг баривчлуулав.



109Page

2 дахь ёдөр Петр, Иохан хоёрыг цэргүүд чирж авчрав.

Муу сумийн тахилчид болон ажилчид тэр хоёроос асуув.

“Хэний зөвшөөрлөөр Есүсийн тухай ярьж байна вэ?”

“ Миний ярьж байгаа зүйл бол зөвхөн Есүс. Есүс тэр суумгай хүнийг эдгээж өгсөн”

гэж Петр маш зоригтой хариуллаа.

“Дахиж Есүсийн тухай ярьж болохгүй шүү . Хэрэв ярьсан байвал та нарыг зүгээр өнгөрөөхгүй гэж мэдээрэй” гэж тэд Петр, Иохан хоёрыг сурдуулэв.

“Тэгсэн ч бид Бурханы үгэнд дуулгавартай хандах болно”

Петр их сурч мэдсэн хүн биш боловч Бурханы өгсөн мэргэн ухаанаар олон хүний өмнө зоригтойгоор ярьж байв.

Тахилч болон сумийн ажилчид нь маш гайхаж байлаа.

Тэд Петр, Иохан хоёрт хэлэх үг байсангүй.



110Page

Суумгай хүнийг эдгэрсэнийг хараад олон хүмүүс Есүст итгээд зогсохгүй,

Бурханд итгэж алдарыг өргөж байв. Үүнээс хойш Петр явсан газар бүрдээ Есүсийн тухай ярьж байв. Тийм учраас Петрээр дамжуулан маш олон хүмүүс Есүс бол Бурханы Хүү, бидний Аврагч хэмээн итгэж байлаа.



111Page